


МОНГОЛ УЛСАД
ФРАНЦЫН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГИЙГ
ҮҮСГЭН БАЙГУУЛАХ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ НЬ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОН

БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ

энэхүү Хэлэлцээрийн зорилгоор цаашид хамтад нь “Талууд” гэж нэрлэнэ.



Монгол, Франц хоёр улс найрамдалт харилцаа, хамтын ажиллагааны хэлхээ холбоогоо бэхжүүлэх, стратегийн түншлэлийг хөгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй байгааг дурдаж;


Хоёр улс хоорондын эдийн засаг, санхүүгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх, өргөжүүлэх нийтлэг хүсэл эрмэлзлийг сайшаан;

Францын хөгжлийн агентлаг (цаашид “ФХА” гэх) болон түүний харьяа байгууллагууд болох хувийн хэвшлийн хөгжлийн санхүүжилтийн чиглэлээрх Эдийн засгийн хамтын ажиллагааг дэмжих, оролцоог хангах компани (цаашид “ПРОПАРКО” гэх), түүнчлэн Францын туршлага, техникийн хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээрх Экспертиз Франц байгууллага (цаашид ЭКСПЕРТИЗ ФРАНЦ гэх) нь ФХА групп (цаашид “ФХА групп” гэх)-ийг бүрдүүлэх бөгөөд тэдгээр нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулахыг; мөн энэхүү Хэлэлцээрийн хүчинтэй хугацаанд “ФХА групп” гэсэн нэр томьёо нь ФХА группийг бүрдүүлж буй гурван байгууллагыг (ФХА, ПРОПАРКО болон ЭКСПЕРТИЗ ФРАНЦ) дангаараа эсвэл хамтдаа илэрхийлнэ гэдгийг хүлээн зөвшөөрч;

ФХА групп нь хөгжиж буй орнуудад Францын хөгжлийн албан ёсны тусламжийг хэрэгжүүлдэг гол байгууллага бөгөөд 100 гаруй улс орнууд дахь төлөөлөгчийн газруудаар дамжуулж, дэлхийн 150 гаруй оронд үйл ажиллагаа явуулдаг болохыг дурдаж;

ФХА групп нь Францын Засгийн газрын хяналт дор аж үйлдвэржилт болон арилжааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийтийн байгууллага бөгөөд дүрэм нь Францын мөнгө, санхүүгийн тухай хуулиар тодорхойлогддог гэдгийг дурдаж, дараахыг тэмдэглэв:

- ядууралтай тэмцэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих, шинээр гарч ирж буй болон хөгжиж буй орнууд, Францын хилийн чанад дахь нутаг дэвсгэрт нийтийн сайн сайхан байдлыг хамгаалан хадгалахад оролцох;
- Францын Европ, гадаад хэрэг болон олон улсын хөгжлийн яам, Эдийн засаг, санхүү, аж үйлдвэр, цахим засаглалын яам, Дотоод хэрэг болон хилийн чанад дахь нутаг дэвсгэрийн яамны хяналт, нягт хамтын ажиллагаа, удирдлага дор үйл ажиллагаа явуулж, Францын хөгжлийн албан ёсны тусламжийн бодлогыг хэрэгжүүлэх;
- хүлээн авагч улсын тэргүүлэх чиглэлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд төр, орон нутгийн засаг захиргааны байгууллага, төрийн болон хувийн санхүүгийн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд буцалтгүй тусламж, урт хугацааны зээл, баталгаа олгох, эсхүл бусад чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бизнес, аж ахуйн нэгжүүдийн хувьцааг худалдан авах хэлбэрээр идэвхтэй үйл ажиллагаа явуулах;



- мөн зөвлөгөө өгөх, сургалт, техникийн туслалцаа үзүүлэх зэрэг үйл ажиллагааг эрхэлдэг.

ПРОПАРКО нь Франц Улсын хуулийн хүрээнд 1977 онд компани хэлбэрээр үүсгэн байгуулагдсаныг дурдаж, дараахыг тэмдэглэв:

- Францын хөгжлийн төлөөх санхүүгийн байгууллага бөгөөд ФХА нь үүний ихэнх хувийг эзэмшдэг;
- “Journal officiel de la République Française” сэтгүүлд 2021 оны 8 дугаар сарын 5-ны өдөр нийтлэгдсэн, хүртээмжтэй хөгжил, ядуурал, дэлхийн тэгш бус байдлын эсрэг тэмцэх тухай 2021 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн 2021-1031 дугаар Францын хуульд туссан хөгжил, олон улсын эв санааны нэгдлийн чиглэлээр Францын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэгч;
- ФХА-ийн удирдлага дор үйл ажиллагаа эрхэлдэг, Францын Засгийн газрын нягт хяналтад байдаг ба Захирлуудын зөвлөлд Сангийн асуудал эрхэлсэн яам, Гадаад хэргийн асуудал эрхэлсэн яам зэрэг байгууллагын төлөөлөгчид болон Засгийн газрын комиссар оролцдог нь үүнийг нотолдог;
- Тогтвортой Хөгжлийн Зорилтууд (ТХЗ)-ыг биелүүлэхийн тулд шинээр гарч ирж буй болон хөгжиж буй орнуудад тогтвортой хөгжил, өсөлтийг дэмжих чиглэлээр хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих үндсэн зорилготой;
- эдийн засгийн хувьд үр ашигтай, нийгэмд эрх тэгш байдал үүсгэх, байгаль орчинд ээлтэй, санхүүгийн хувьд ашигтай үйл ажиллагааг санхүүжүүлдэг;
- хамгийн орлого багатай орнуудаас эхлэн байгаль орчны болон нийгмийн өндөр хариуцлагатай хөгжиж буй томоохон орнуудыг хамран хөрөнгө оруулалт хийдэг;
- хөгжиж буй орнуудын хувийн хөрөнгө оруулагчдын шаардлагатай хэрэгцээг хангахад туслах санхүүгийн иж бүрэн хэрэгслийг санал болгодог (зээл, хувьцаат хөрөнгө, холимог хэлбэрээр оролцох хэрэгсэл, баталгаа, техникийн туслалцаа гэх мэт);
- зөвхөн тухайн улсын санхүүгийн байгууллага ижил төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох боломжгүй тохиолдолд, эсхүл тэдгээр улс дахь санхүүгийн байгууллагууд санхүүжилт олгохын тулд нэмэлт дэмжлэг шаардлагатай үед хамтран ажилладаг;

ЭКСПЕРТИЗ ФРАНЦ нь 2021 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 2021-1031 дугаар хуулийн дагуу ФХА группийн харьяа байгууллага болж нэгдсэн ба хүртээмжтэй



хөгжлийг дэмжих, дэлхийн тэгш бус байдалтай тэмцэх зорилгоор Франц Улсын техникийн хамтын ажиллагааг хэрэгжүүлдэг гэдгийг дурдаж, дараахыг тэмдэглэв:

- хуулийн дагуу хүлээн зөвшөөрөгдсөн нийтийн албаны зорилгыг хэрэгжүүлнэ. Үндсэн үйл ажиллагаа нь засаглал, аюулгүй байдал, уур амьсгал, эрүүл мэнд, боловсрол, соёл зэрэг салбар дахь төрийн бодлогод тулгуурласан төсөл боловсруулж, хэрэгжүүлэх, өндөр ур чадвартай мэргэжилтнүүдийг (хүлээн авагч улсын хүсэлтээр илгээсэн мэргэжилтнүүд, техникийн ажилтнуудыг оролцуулан) дайчлах явдал юм. Үүний үйл ажиллагааг хоёр болон олон талт хандивлагчид, ихэвчлэн Франц Улс өөрийн хөгжлийн агентлагаар дамжуулан санхүүжүүлэх бөгөөд мөн “Экспертиз Франц” нь Европын Холбооны хэрэгжүүлэгч агентлаг, төлөөлөгч донор байгууллагаар ажиллаж болно;
- түншүүддээ (гол төлөв засгийн газрууд, мөн бүс нутгийн байгууллага, орон нутгийн засаг захиргаа, иргэний нийгмийн байгууллагууд) өөрсдийн институт, бодлогыг дэмжихэд мөн төлөөлөгчдийнхөө мэргэжлийн ур чадварыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Үүний тулд мэргэжилтнүүдийг дайчлах, сургалт, семинар, туршлага судлах сургалт зохион байгуулах, буцалтгүй тусламж үзүүлэх, тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн нийлүүлэх зэрэг өргөн хүрээний үйл ажиллагааг санал болгодог. Энэ хүрээнд үндэсний хэмжээний түншүүдтэй хамтран хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, хэрэгжиж дуусан төслүүдийн хяналт, үнэлгээг хэрэгжүүлнэ.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилтын хүрээнд ФХА групп нь Монгол Улсад санхүүгийн болон техникийн тусалцаа үзүүлэх боломжийг олгох зорилгоор энэхүү Хэлэлцээрийг байгуулах нь Талуудын нийтлэг ашиг сонирхолд нийцэж буйг тэмдэглэн;

Монгол Улсын Засгийн газраас ФХА группийн үйл ажиллагааны хүрээг тодорхойлж, Монгол Улсын хөгжлийн санхүүжилтийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор ФХА группт тодорхой давуу эрх, чөлөөлөлт олгохыг эрмэлзэж буйг дурдаж,

Тусгаар тогтнол, бүрэн эрхт эрх тэгш байдал, дотоод хэрэгт хөндлөнгөөс үл оролцох зарчмуудыг эрхэмлэн дээдлэх үндсэн дээр Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хооронд дараах зүйлийг тохиролцов.

1 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ХЭЛЭЛЦЭЭРИЙН ЗОРИЛГО

ФХА групп нь энэхүү Хэлэлцээрт зааснаар Монгол Улсад санхүүгийн болон техникийн тусламж үзүүлэх, хөрөнгө оруулалт хийх эрхтэй.

Энэхүү Хэлэлцээрийн зорилго нь 3.1-д заасны дагуу ФХА группийн Монгол дахь үйл ажиллагаанд хамаарах нөхцөл, 7.1-д зааснаар ФХА группийн төлөөлөгчийн газрыг байгуулахад оршино. Тухайлбал, энэхүү Хэлэлцээр нь тухайн улс дахь ФХА



группийн үйл ажиллагаа болон ФХА группийн төлөөлөгчийн газрын статустай холбоотой хууль эрх зүй, татвар, санхүүгийн нөхцөлийг тодорхойлно.

2 ДУГААР ЗҮЙЛ. ФХА ГРУППИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

2.1. ФХА группийн харьяа байгууллагууд нь Монгол Улсад хуулийн этгээдийн эрх, эрх зүйн чадамжтай байх бөгөөд үүний хүрээнд гэрээ хэлэлцээр байгуулах, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө (газраас бусад) худалдан авах, түрээслэх, захиран зарцуулах, аль ч улсын харьяалалтай ажилтныг ажилд авах, түүнчлэн Монгол Улсад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулах, энэхүү Хэлэлцээрт заасны дагуу өөрийн эрхэм зорилгыг биелүүлэхэд шаардлагатай аливаа арга хэмжээ, журмыг хэрэгжүүлэх боломжтой.

2.2. ФХА групп нь 2.1 дүгээр заалтад заасан бүх гүйлгээний хувьд мөн чанараараа, эсхүл тогтсон заншлын дагуу (байнгын бус оршин суугчтай байгуулсан гэрээ, гадаадын бараа, үйлчилгээ авах, олон улсын санхүүгийн үүрэг гэх мэт) гадаад валютаар (тэр дундаа евро, эсхүл ам.доллар) төлөх ёстой гүйлгээнээс бусад тохиолдолд мөнгөн үүргийг Монгол Улсын үндэсний валютаар барагдуулахын тулд бүхий л хүчин чармайлтаа гаргана.

3 ДУГААР ХЭСЭГ. ФХА ГРУППИЙН МОНГОЛ УЛСАД ЯВУУЛЖ БОЛОХ ЗӨВШӨӨРӨГДСӨН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Монгол Улс дахь ФХА-ын үйл ажиллагаа болон санхүүжүүлэх төсөл, байгууллагыг сонгох үйл ажиллагаа нь Монгол Улсын Засгийн газрын тухайн үед мөрдөгдөж буй богино, дунд, урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд тодорхойлсон тэргүүлэх чиглэлүүдээр зохицуулагдана.

3.2. ФХА групп нь энэхүү Хэлэлцээрийн оршил хэсэгт заасан Талуудын харилцан тохиролцсон үүрэг болон Хэлэлцээрийн зүйл, заалтын дагуу хуулиар хүлээсэн үүргээ биелүүлнэ. Тодруулбал:

- а) Монгол Улсад төрийн эрх бүхий байгууллагууд, улсын болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд, түүнчлэн дотоод, гадаад болон олон улсын хувийн, эсхүл улсын холбоод, байгууллагууд, мөн Монгол Улсад төвтэй аливаа хуулийн этгээд, түүний дотор банк, санхүүгийн байгууллагуудад евро, ам.доллар, эсхүл Талуудын тохиролцсон бусад валютаар зээл, буцалтгүй тусламж, баталгаа хэлбэрээр санхүүгийн дэмжлэг, мөн санхүүгийн болон техникийн туслалцааны аливаа хэлбэрийг үзүүлэх;
- б) Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын дагуу аливаа борлуулагчаас бүх төрлийн компанийн хувьцааг худалдан авах, хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулж хувь эзэмших, мөн тухайн хувь эзэмшлээ шилжүүлэх, эсхүл худалдан борлуулах;



- с) Улсын болон хувийн хэвшлийн этгээдүүдэд зөвлөх үйлчилгээ, техникийн туслалцаа, сургалт, судалгааны үйлчилгээ үзүүлэх, эсхүл бараа нийлүүлж, ажил гүйцэтгэх.

3.3. Дээр дурдсан үйл ажиллагаа бүр нь тухайн үйл ажиллагаа, эсхүл гүйцэтгэлд хамаарах талуудын үүрэг, амлалтыг тодорхойлсон тусгайлсан гэрээний дагуу зохицуулагдана. Тал бүр өөрийн улсын дотоодын хууль тогтоомж, дүрэм журмын дагуу тухайн гэрээний хүчин төгөлдөр байдал, эсхүл хүчин төгөлдөр болохыг хангахад шаардлагатай аливаа албан ёсны журмыг хөнгөвчлөхийн тулд бүхий л хүчин чармайлтаа гаргах үүрэг хүлээнэ.

3.4. Энэхүү Хэлэлцээрийн 3.2 (а) заалтад заасан санхүүгийн туслалцаа, тухайлбал зээл, баталгаа, буцалтгүй тусламжийн гэрээг хэрэгжүүлэх зорилгоор ФХА-аас Монгол Улсад байгуулсан санхүүжилтийн гэрээнүүд нь Франц Улсын хуулиар зохицуулагдана.

3.5. ФХА группийн Монгол Улс дахь үйл ажиллагааг 3.2 дугаар заалтын дагуу зөвшөөрсөн тул нэмэлт зөвшөөрөл шаардахгүй. Чингэхдээ Монгол Улсад олгох Засгийн газрын зээлийн хувьд хүчин төгөлдөр болохын тулд Монгол Улсын Их Хурлаар урьдчилан соёрхон батлуулах шаардлага хэвээр үлдэнэ.

4 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ФХА БОЛОН ПРОПАРКОГИЙН МОНГОЛ УЛС ДАХЬ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭЛБЭР

Энэхүү Хэлэлцээрийн 3.2 дугаар заалтын дагуу зөвшөөрөгдсөн ФХА болон Пропаркогийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг Франц Улсад байрлах тэдгээрийн төв байрнаас шийдвэрлэж, хэрэгжүүлэх бөгөөд иймд тэдгээрийг хил дамнасан үйл ажиллагаа гэж үзнэ. Үүнтэй холбоотойгоор ФХА, Пропарко болон тэдгээрийн Төлөөлөгчийн газрууд (хэрэв байгаа бол) нь Монгол Улсад банк болон санхүүгийн бусад байгууллагын статусгүй байна.

5 ДУГААР ЗҮЙЛ. ВАЛЮТЫН ХӨРВҮҮЛЭГ БА ШИЛЖҮҮЛЭГ

5.1. Энэхүү Хэлэлцээрийн дагуу ФХА групп нь дараах эрхийг эдэлнэ:

- (i) Монгол Улсын нутаг дэвсгэрт аль ч валютаар данс эзэмших;
- (ii) Монгол Улсын Засгийн газар болон ФХА групп өөрөөр тохиролцоогүй бол, ФХА группэд төлөх ёстой аливаа дүн, тухайлбал санхүүжилтийн үндсэн төлбөр болон хүүгийн буцаан төлөлт, хугацаа хэтрүүлсний хүү, дагалдах хураамж, түүнчлэн ФХА группийн Монгол Улс дахь үйл ажиллагааг хэрэгжүүлсэн буюу гүйцэтгэсний үр дүнд төлөгдөх бусад аливаа дүнг хөрвүүлэлт хийх өдөр Монголбанкнаас зарласан ханшид үндэслэн эрх бүхий банкнуудаар дамжуулан холбогдох ханшаар гадаад валютад хөрвүүлэх, мөн



(iii) энэхүү 5.1 дүгээр зүйлийн (ii)-д заасан гадаад валютаарх аливаа дүнг Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадагш чөлөөтэй шилжүүлэх.

5.2. ФХА группээс олгосон санхүүжилтийн үр шимийг хүртэгчид, тухайн санхүүжилтийн батлан даагчид болон хөрөнгө шилжүүлгийг хариуцаж буй зуучлагч банкнууд нь мөн адил 5.1 дүгээр заалтын давуу эрхийг эдэлнэ.

5.3. Зээлдэгчийн, эсхүл ФХА группээс олгосон санхүүжилтийн үр шимийг хүртэгчийн хүсэлтээр, аливаа санхүүгийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад тухайн зээлдэгч, эсхүл үр шимийг хүртэгчийн Монгол Улсын нутаг дэвсгэрт байрладаггүй ажил, үйлчилгээ үзүүлэгчдэд төлбөрийг шууд шилжүүлэх эрхийг ФХА группэд олгоно.

5.4. Монгол Улсад үйл ажиллагаа явуулах албан ёсны эрх бүхий банкнууд нь дараах үйл ажиллагааг гүйцэтгэх эрхтэй:

(i) Монгол Улсын Засгийн газар болон ФХА групп өөрөөр тохиролцоогүй бол, ФХА группийн төлбөр төлөгчдөөс хүлээн авсан төгрөгийг хөрвүүлэлт хийх өдөр Монголбанкнаас зарласан ханшид үндэслэн эрх бүхий банкнуудаар дамжуулан холбогдох ханшаар евро, ам.доллар, эсхүл чөлөөтэй хөрвөх бусад валютад хөрвүүлэх, мөн


(ii) Тухайн гадаад валютыг ФХА группийн Франц Улс дахь, эсхүл гадаад дахь банкны данс руу шилжүүлэх.

5.5. Монгол Улс дахь банкнууд хөрвүүлэлт буюу шилжүүлэг хийхээс татгалзах, эсхүл хөрвүүлэлт, шилжүүлэг хийхэд хүрэлцэхүйц гадаад валютгүй байх, эсхүл ФХА группийн төгрөгийг хөрвүүлж, гадаад руу шилжүүлэх эрхгүй байснаас шалтгаалан ямар нэгэн байдлаар хөрвүүлэлт, шилжүүлэг хийгдээгүй тохиолдолд Монгол Улсын Засгийн газар нь өөрийн байгуулсан Засгийн газрын санхүүжилттэй холбоотойгоор холбогдох арга хэмжээг авч, аль болох түргэн хугацаанд, бүхий л хүчин чармайлтаа гаргаж (i) хөрвүүлэлт хийх өдөр Монголбанкнаас зарласан ханшид үндэслэн холбогдох ханшаар төгрөгийг гадаад валютад хөрвүүлэх бөгөөд (ii) энэхүү Хэлэлцээрийн дагуу Монголбанкаар дамжуулан тухайн валютын шилжүүлгийг ФХА группийн гадаад дахь банкны дансанд гүйцэтгэнэ.

6 ДУГААР ЗҮЙЛ. ТАТВАР

6.1. Дараах төрлийн татваруудыг чөлөөлөх боломжтой байна: (i) нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ), (ii) тухайн зээлийн гэрээнд заасан гаалийн татвар.

Ийм татварын чөлөөлөлт нь зөвхөн төрийн санхүүжилтийн гэрээний хөрөнгөөр шууд санхүүжүүлсэн бараа, бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, ажил болон үйлчилгээнд (зөвлөх үйлчилгээг оролцуулан) хамаарна.



Аливаа татварын чөлөөлөлт нь зөвхөн зээлийн гэрээнд заасан хэмжээгээр үйлчлэх бөгөөд тус гэрээг Монгол Улсын Их Хурал (Парламент) соёрхон баталсны дараа хэрэгжинэ. Доорх 6.2 дугаар заалтыг хөндөхгүйгээр, соёрхон баталсан зээлийн гэрээнд тодорхой зааснаас бусад өөр ямар ч татвар, хураамжийг чөлөөлөхгүй.

6.2. Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Конвенц (цаашид “Давхар татварын гэрээ” гэх)-ийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн (с)-д заасан зорилгоор ФХА болон Пропарког зээлийн байгууллага гэж үзнэ. Үүний дагуу, Монгол Улс нь Давхар татварын гэрээний дагуу ФХА болон Пропаркод төлсөн, эсхүл шилжүүлсэн хүү болон хураамжид татвар ногдуулахгүй.

6.3. Буцалтгүй тусламжаар санхүүжүүлсэн бүх бараа, бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, эсхүл үйлчилгээ, тухайлбал 3.2 (с) заалтад заасан Экспертиз Францын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зориулж худалдан авсан бараа, үйлчилгээ нь дотоодын хууль тогтоомжийн дагуу тогтоосон журмаар нэмэгдсэн, өртгийн албан татвар, гаалийн татвар болон бусад холбогдох хураамжаас чөлөөлөгдөнө.

6.4. Татварын зохицуулалтын хүрээнд ФХА группийн харьяа байгууллагууд болон тэдгээрийн Төлөөлөгчийн газар (ууд) нь Монгол Улсад байнгын төлөөлөгчийн газрын статусгүйд тооцно.

7 ДУГААР ЗҮЙЛ. ФХА ГРУППИЙН СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР – АЖИЛТНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

7.1. ФХА группийн Монгол дахь Төлөөлөгчийн газар(ууд)

- (а) ФХА группийн харьяа байгууллагууд нь Монгол Улсын Засгийн газрын урьдчилан зөвшөөрснөөр Улаанбаатар хотод болон Монгол Улсын аль ч газарт нэг буюу хэд хэдэн төлөөлөгчийн газар (цаашид “Төлөөлөгчийн газар” гэх) нээх эрхтэй.
- (б) Монгол Улсын Засгийн газар нь аливаа Төлөөлөгчийн газрыг нээх болон үйл ажиллагаа эрхлэхэд Монгол Улсын дотоодын хууль тогтоомж, дүрэм журмын дагуу дэмжлэг үзүүлэх бөгөөд энэ нь энэхүү Хэлэлцээрийн дагуу олгогдсон эрх, давуу эрхэд нөлөөлөхгүй гэж ойлгоно.
- (в) ФХА группийн харьяа байгууллагуудын Монгол Улс дахь Төлөөлөгчийн газар (ууд) нь тэдгээрийн Монгол Улсад хэрэгжүүлж болох төслүүдийг тодорхойлох, эдгээр төсөлтэй холбоотой баримт бичгийг бэлтгэх, хэлэлцээ хийх, түүнчлэн тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих үүргийг хүлээнэ.

ФХА группийн Төлөөлөгчийн газар (ууд) нь үйл ажиллагаагаа энэхүү Хэлэлцээрийн дагуу явуулна.



(г) Аливаа Төлөөлөгчийн газар нь дараах хөнгөлөлт, нөхцөлүүдийг эдэлнэ:

- Төлөөлөгчийн газар нь эдгээр зүйлсийг импортлох, эсхүл худалдан авахад гаалийн татвар болон холбогдох тохиолдолд НӨАТ-аас чөлөөлөгдөнө: (i) Төлөөлөгчийн газрын бүх Гадаад ажилчдын хувийн болон гэр ахуйн эд хогшил (үүнд тавилга, гэр ахуйн бараа болон тэдгээрийн хувийн хэрэгцээ, хэрэглээний бусад бараа, мөн Төлөөлөгчийн газрын Гадаад ажилтан бүрд нэг автомашин), (ii) энэхүү Хэлэлцээрийн дагуу Төлөөлөгчийн газарт зориулсан бүх тавилга, тоног төхөөрөмж, үүнд албаны автомашинууд;
- Дээр дурдсан тоног төхөөрөмж болон автотээврийн хэрэгслийг хожим нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ийм татвараас чөлөөлөгдөх эрхгүй буюу ижил төстэй давуу эрх эдлээгүй хувь хүн, хуулийн этгээдэд худалдсан, эсхүл шилжүүлсэн тохиолдолд гаалийн татвар зэрэг бүх төрлийн татварыг төлнө;
- Төлөөлөгчийн газар, түүний байр, эд хөрөнгө болон бусад хөрөнгө нь нэгжлэг хийх, хураах, дайчлах, болон өмчлөх эрхийг албадан хураах явдлаас чөлөөлөгдөнө;
- Төлөөлөгчийн газрын албан захидал харилцаа, архив, түүнд хамаарах буюу түүний эзэмшилд байгаа бүх баримт бичиг халдашгүй дархан байх бөгөөд Монгол Улсын эрх бүхий байгууллагууд ФХА группийн урьдчилан өгсөн зөвшөөрөлгүйгээр Төлөөлөгчийн газрын байранд нэвтрэхгүй;
- ФХА группээс олгосон буюу удирдсан зээлийн гэрээ, буцалтгүй тусламж, эсхүл баталгаанаас үүдэлтэй өр, нэхэмжлэл болон бусад үүрэг хүлээлт нь ФХА групп, эсхүл түүний Төлөөлөгчийн газрын эсрэг чиглэсэн ямар ч хэлбэрийн хураан авах, битүүмжлэх, эсхүл албадан гүйцэтгэх аливаа арга хэмжээнээс бүрэн хамгаалагдана.

(д) Монгол Улсын Засгийн газар нь ФХА Групп, эсхүл түүний Төлөөлөгчийн газар (ууд)-ын хөрөнгө, санхүүг улсын өмч болгохгүй, хураан авахгүй байх, мөн ФХА групп, эсхүл түүний Төлөөлөгчийн газар (ууд) эдгээр хөрөнгө, санхүүгээ ашиглах боломжгүй болоход хүргэх аливаа арга хэмжээ авахгүй байх үүрэг хүлээнэ.

Хэрэв үндэслэл бүхий нийтийн ашиг сонирхлын үүднээс ийм арга хэмжээ авсан тохиолдолд ФХА группэд зохих нөхөн олговрыг хугацаа алдалгүй, чөлөөтэй хөрвөх валютаар олгоно. Санхүүгийн нөхөн олговрыг хараат бусаар тогтоосон зах зээлийн үнээр Талууд харилцан зөвшилцөж, хүлээн зөвшөөрнө.



- (е) Монгол Улсын Засгийн газрын хүсэлтээр, ФХА групп нь хамтын ажиллагааны болон үнэнч шударга зарчмын үүднээс Монгол Улс дахь өөрийн үйл ажиллагааны талаарх холбогдох мэдээллээр хангахыг эрмэлзэнэ.

7.2. ФХА группийн гадаад ажилчид

- (а) ФХА групп нь өөрийн Төлөөлөгчийн газар (ууд)-ын хэвийн, үр ашигтай үйл ажиллагаанд шаардлагатай гэж үзсэн Монгол Улсын харьяат бус бөгөөд Монгол Улсад оршин суух визгүй ажилчдын (цаашид “Гадаад ажилчид” гэх) тоо болон мэргэшлийн түвшнийг тогтооно.

ФХА групп нь гадаад ажилчдаа өвчлөл, жирэмслэлт, амаржсаны болон эцэг эх болох болох үеийн чөлөө, хөгжлийн бэрхшээл, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, өндөр насны тэтгэвэр зэрэг эрсдэлээс хамгаалсан, Франц Улсын нийгмийн хамгааллын ерөнхий тогтолцоотой дүйцэхүйц хэмжээний байгууллагын нийгмийн даатгалын системээр шууд хангана.

Гадаад ажилчид нь Монгол Улсын нийгмийн хамгааллын тухай хууль тогтоомжид захирагдахгүй бөгөөд тухайлбал, Монгол Улсын нийгмийн даатгалын тогтолцоонд хамрагдах болон ажилтны хариуцах нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс чөлөөлөгдөнө.

Гадаад ажилчдын бүх цалин хөлс, нэмэгдэл тэтгэмж, зардлыг ФХА групп бүрэн хариуцах бөгөөд эдгээр нь Монгол Улсад хувь хүний орлогын албан татвар, бусад аливаа хэлбэрийн татвар, эсхүл нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөгдөнө.

- (б) Монгол Улсын Засгийн газар нь гадаад ажилчид болон тэдний гэр бүлийн гишүүд, үүнд тэдний эхнэр/нөхөр буюу хамтран амьдрагч, эцэг эх, өвөг эцэг, эмэг эх, хүүхдүүдийн Монгол Улсад нэвтрэх, байх, оршин суух, чөлөөтэй зорчих болон гарахтай холбоотой албан ёсны бүрдүүлэлтийг хөнгөвчилнө.

- (в) Монгол Улсын Засгийн газар нь гадаад ажилчид болон тэдний гэр бүлийн гишүүд, үүнд эхнэр/нөхөр буюу хамтран амьдрагч, эцэг эх, өвөг эцэг, эмэг эх, хүүхдүүдэд дараах хөнгөлөлт, нөхцөлүүдийг олгоно:

- Монгол Улсын нутаг дэвсгэрт нэвтрэх зөвшөөрөл, олон удаа нэвтрэх виз олгох, мөн оршин суух зөвшөөрөл олгох;
- Монгол Улсад анх томилогдон ирж үүрэгт ажилдаа орох үед өөрсдийн хувийн болон гэр ахуйн эд хогшлыг татваргүйгээр импортлох эрх;
- Хувийн эд хөрөнгийг Монгол Улс руу оруулах буюу Монгол Улсаас гаргахад шаардлагатай чөлөөтэй шилжүүлэх аливаа зөвшөөрлийг олгох;



- Гадаад ажилтны эхнэр/нөхөр буюу хамтран амьдрагчид тухайн ажилтны виз, эсхүл нэвтрэх зөвшөөрлийн хугацаатай ижил хугацаагаар Монгол Улсад хөдөлмөр эрхлэх эрх бүхий ажлын зөвшөөрөл олгох.

(г) Монгол Улсын Засгийн газар нь гадаад ажилчдад зөвхөн албан үүргээ гүйцэтгэх явцдаа гаргасан үйлдэлд нь холбогдуулан шүүхийн халдашгүй дархан эрх олгоно. Энэхүү дархан эрх нь тэднийг Францын талын шүүхийн харьяаллаас чөлөөлөхгүй.

7.3. ФХА группийн Монгол Улсын харьяат буюу Монгол Улсад байнга оршин суугч ажилчид

ФХА групп нь Монгол Улс дахь үйл ажиллагааныхаа хүрээнд Монгол Улсын хөдөлмөрийн тухай хууль болон нийгмийн хамгааллын тухай хууль тогтоомж, дүрэм журмын дагуу Монгол Улсын харьяат буюу байнга оршин суугч иргэдийг ажиллуулж болно.

7.4. Монгол Улс дахь түр хугацааны томилолтууд

ФХА групп нь Монгол Улс дахь үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх зорилгоор түр томилолтын баг илгээх, эсхүл олон улсын зөвлөхүүдийг (цаашид “Түр хугацааны мэргэжилтнүүд” гэх) томилон ажиллуулж болно.

Монгол Улсын Засгийн газар нь ийм Түр хугацааны мэргэжилтнүүд буюу түр томилолтын багийн гишүүдийг Монгол Улсын нутаг дэвсгэрт нэвтрэх, байх, гарахтай холбоотой шаардлагатай зөвшөөрлийг цаг хугацаанд нь шуурхай авахад чиглэсэн холбогдох арга хэмжээг авна.

Монгол Улсын Засгийн газар нь түр томилолтын багийн гишүүдэд зөвхөн албан үүргээ гүйцэтгэх явцдаа гаргасан үйлдэлд нь холбогдуулан шүүхийн халдашгүй дархан эрхийг олгоно. Энэхүү дархан эрх нь тэднийг Францын талын шүүхийн харьяаллаас чөлөөлөхгүй.

8 ДУГААР ЗҮЙЛ. ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

8.1. ФХА группийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхтэй холбоотой албан ёсны бүрдүүлэлт, журмыг хөнгөвчлөх зорилгоор Монгол Улс нь энэхүү Хэлэлцээрийг шуурхай бөгөөд бүрэн хэрэгжүүлэх боломжийг олгох үүднээс шаардлагатай бүх мэдээллийг дотоодын хууль тогтоомж, дүрэм журмын дагуу тус группийн харьяа байгууллагуудад хүргүүлэх бөгөөд үүний тулд шаардлагатай бүхий л арга хэмжээг авна.

8.2. Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн ФХА групп нь Монгол Улсын аливаа эрх бүхий байгууллагууд, албан тушаалтан болон төрийн захиргааны аль ч байгууллагад энэхүү Хэлэлцээрийг иш татах, эсхүл хуулбарыг нь үзүүлэх



хэлбэрээр танилцуулж болно. ФХА группийн аливаа харьяа байгууллагаас санхүүжилт авч буй үр шимийг хүртэгчид, эсхүл түүний хамтран гэрээ байгуулагч талуудад энэхүү Хэлэлцээрт заасан эрхийг хэрэгжүүлэхийг шаардах боломжийг олгох үүднээс холбогдох байгууллагуудад үзүүлэх зорилгоор Хэлэлцээрийн хуулбарыг тухайн үр шимийг хүртэгчид, эсхүл хамтран гэрээ байгуулагчдад дамжуулах эрхийг ФХА группэд олгоно.

9 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ХЭЛЭЛЦЭЭР ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ, ХҮЧИНТЭЙ БАЙХ ХУГАЦАА, ЦУЦЛАХ БОЛОН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

9.1. Хүчин төгөлдөр болох

Талууд энэхүү Хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгоход шаардагдах дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг бүрэн хангасан тухайгаа нөгөө талдаа бичгээр мэдэгдэх бөгөөд хамгийн сүүлийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойших хоёр дахь сарын эхний өдрөөс эхлэн Хэлэлцээр хүчин төгөлдөр болно.

Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болмогц Монгол Улсын Засгийн газар нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн 102 дугаар зүйлийн дагуу уг Хэлэлцээрийг НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газарт бүртгүүлэх ажлыг гүйцэтгэнэ. НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газраас баталгаажуулалтыг хүлээн авмагц НҮБ-ын бүртгэлийн дугаарыг дамжуулах замаар Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газарт тус бүртгэлийн талаар мэдээлнэ.

Энэхүү Хэлэлцээр нь ФХА группийн харьяа байгууллагуудаас Монгол Улсын Засгийн газрын зөвшөөрлөөр Монгол Улсад байгуулсан, одоо хэрэгжиж буй гэрээнүүдэд, мөн энэхүү Хэлэлцээрийн 3.2 дугаар заалтад л зөвшөөрсөн үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд нэгэн адил үйлчилнэ.

9.2. Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах

Талууд бичгээр харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү Хэлэлцээрт хэдийд ч нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Аливаа нэмэлт, өөрчлөлтийг Талууд хүчин төгөлдөр болгоход шаардлагатай дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг гүйцэтгэсний дараа хүчин төгөлдөр болох бөгөөд энэхүү Хэлэлцээрийн салшгүй хэсэг байна.

9.3. Маргааныг шийдвэрлэх

Энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах, эсхүл хэрэгжүүлэх, түүний боломжит нэмэлт хэлэлцээрүүд, эсхүл ФХА групп, Төлөөлөгчийн газар (ууд)-тай холбоотой аливаа асуудал, эсхүл энэхүү Хэлэлцээртэй холбоотойгоор Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн



газар хоорондын харилцаанаас үүдэн гарсан Талуудын хоорондох аливаа маргааныг дипломат шугамаар Талууд шууд хэлэлцээ хийх замаар найрамдлын журмаар шийдвэрлэнэ.

9.4. Хүчинтэй байх хугацаа болон цуцлах

Энэхүү Хэлэлцээрийг тодорхойгүй хугацаагаар байгуулав. Аль нэг Тал нөгөө Талдаа дипломат шугамаар зургаан (6) сарын өмнө бичгээр мэдэгдэл өгөх замаар Хэлэлцээрийг хэдийд ч цуцалж болно. Ийм нөхцөлд мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш зургаан (6) сарын хугацаа өнгөрсний дараа Хэлэлцээр дуусгавар болно. Энэхүү Хэлэлцээрийн хүчинтэй хугацаа дуусгавар болсон нь Хэлэлцээрийн хүрээнд эхлүүлсэн тодорхой үйл ажиллагааны хэрэгжилтэд нөлөөлөхгүй бөгөөд тэдгээр үйл ажиллагаа холбогдох гэрээний дагуу бүрэн дуусах хүртэл үргэлжилнэ.

..... хотноо оны сарын -ны өдөр монгол, франц, англи хэлээр тус бүр гурван эх хувь үйлдэв. Энэхүү Хэлэлцээрийг тайлбарлахад зөрүү гарвал англи хэл дээрх эх бичвэрийг удирдлага болгоно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ

БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature:

2026 оны 6 сарын 22 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION